



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын
11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

**“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Увс Хүнс” Хувьцаат компани УБГД: 1510001008, РД: 2001969 Үнэт цаасны код: HUN Хаяг: Увс аймаг, Улаангом сум, 5-р баг Утас: +976-7555-8686 Имэйл: info@uvskhuns.mn Вэб хаяг: www.uvskhuns.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний үйлдвэрлэл, газар тариалан
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	112,716
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Хагас жилийн тайлан бэлтгэсэн: Захиргаа, хүний нөөцийн албаны дарга О.Оюунхүү Хянасан: Гүйцэтгэх захирал Л.Нямгэрэл



1.

Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	2026.01.01	мян.төг 2026.06.30
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	4,529,412.4	4,999,211.8
	Эргэлтийн бус хөрөнгө	1,823,979.8	1,727,088.6
	Нийт хөрөнгө	6,353,392.2	6,726,300.4
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	250,297.6	307,921.6
	Эздийн өмч	6,103,094.6	6,418,378.8
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	6,353,392.2	6,726,300.4

Орлогын тайлан	Үзүүлэлт	2026.01.01	мян.төг 2026.06.30
	Борлуулалтын орлого	7,798,624.8	3,303,221.3
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,417,453.8	1,965,570.6
	Нийт ашиг	3,381,171.0	1,337,650.7
	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	1,819,054.6	350,802.5
	Орлогын албан татварын зардал	184,570.5	35,518.3
	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	1,634,484.1	315,284.2

Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	2026.01.01	мян.төг 2026.06.30
	Энгийн хувьцаа	14,736.7	14,736.7
	Дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.5	847,420.5
	Эздийн өмчийн бусад хэсэг	179,179.7	179,179.7
	Хуримтлагдсан ашиг	5,061,757.7	5,377,041.9
	Нийт эздийн өмчийн дүн	6,103,094.6	6,418,378.8



		МЯН.ТӨГ	
Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	2026.01.01	2026.06.30
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	516,521.8	561,979.5
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	190,464)	271,709.9)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(275,000)	-
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	52,712.9	290,465.6
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,394.1	165,547.4
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	218,260.3	508,725.9
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргадаг. Хагас жилийн тайланг Гүйцэтгэх захирлаар батлуулсан.		
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан дүгнэлт		
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь	43.3% 40.5%
		Цэвэр ашгийн хувь	20.9% 9.5%
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа	18.1 16.2
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	4.6 6.9
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.04 0.05
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүний үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөнд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл		



2026 оны 2-р сарын 9-13-ны өдрүүдэд Малайз Улс, Куала Лумпур хотноо зохион байгуулагдсан Codex Alimentarius Commission-ийн дэргэдэх Өөх тосны асуудлаарх техникийн хорооны 29 дүгээр хуралдаанд (CCFO29) Монгол Улсын санаачилсан чацарганы тосны олон улсын стандарт боловсруулах санал албан ёсоор ажил хэрэг болохоор дэмжигдсэн. Монгол Улс тус стандартыг боловсруулах Цахим ажлын хэсгийг ахлан ажиллахаар болсноор дэлхийн зах зээлд чацарганы тосны үнэ цэнэ, чанар, аюулгүй байдлыг нэгдсэн шаардлагаар баталгаажуулах ажил эхэлсэн. “Увс Хүнс” ХК нь уг олон улсын хуралд чацарганы тосны бүтээгдэхүүний танилцуулга хийж, дээж бүтээгдэхүүнээ илгээж олон улсын төлөөлөгчдөд танилцуулсан.

Бид байгалийн цэвэр түүхий эд, жимсний тосоо агуулсан бүтээгдэхүүнээрээ Монгол Улсын чацарганы салбарын үнэ цэнийг олон улсын тавцанд таниулах боломжтой болсон.

3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/ Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувыцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэлүрамшууллын мэдээлэл Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувыцаа гаргаагүй.
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	Хувыцаа эзэмшигчдийн хурал “Увс Хүнс” ХК-ийн Хувыцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Увс аймаг Улаангом сум 5-р баг компанийн байр захирлын өрөөнд хуралдан дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд: 1. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэн батлав. 2. 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав. 3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгов. “Увс Хүнс” Хувцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүд: - Л.Мөнхнаран - Т.Лхагвасүрэн - Л.Нямгэрэл - Л.Мөнхтуяа - Л.Энхтуяа - Л.Батмөнх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүд: - Ц.Уянга - Ж.Бааст - Н.Оюун



7. **Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл**

Тайлант хугацаанд Компанийн засаглалын кодексын тайланг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр МХБ-ийн сайтад байршуулсан.

Компанийн засаглалын хүрээнд батлагдсан дагаж мөрддөг бодлого, дүрэм, журмыг компанийн <https://uvskhuns.mn/> вэб сайтад бодлого, дүрэм журам хэсэгт байршуулан мэдээлсэн.

8. **Үйл ажиллагаатай холбоотой нэмэлт мэдээлэл**

Хүний нөөц

2026 оны 06 сарын 30-ны байдлаар нийт 87 ажилтан ажилласан бөгөөд 27 эрэгтэй, 60 эмэгтэй ажилтан ажиллаж байна. Дундаж наслалт 35

18 удаагийн онлайн болон танхимын цагийн сургалтад хамрагдсан. Хагас жилд 31 ажилтан шинээр ажилд орсноос 11 ажилтан ажлын байран дээрээ дадлагажиж жинхэлсэн, 1 оюутан танилцах дадлага хийсэн.

"Увс Хүнс" ХК-ийн бүтээгдэхүүнүүд албан ёсоор 2026 оны 01 сарын 16-ны өдрөөс Дархан-уул аймагт Хүслэн бөөний төвд худалдаалагдаж эхэлсэн.

Эрүүл хөрс, цэвэр агаар, уламжлалт аргаар боловсруулсан Нутгийнхаа амтыг дэмжиж, Монгол үйлдвэрлэгчдээ сонгоорой Чанар, шим тэжээл, итгэл-нэг дороос авах боломж бүрдэж байгаа юм.



ХҮСЛЭН
БӨӨНИЙ ТӨВ

Албан ёсоор
худалдаалагдаж
ЭХЭЛЛЭЭ



УВС ХҮНС
УВС ХҮНС ЖАРИЛГААНЫ ХӨДӨӨ



 **Хүслэн бөөний төв**

 **7773-8883**

 **Хүслэн төвийн 1 давхарт**



Улаанбаатар хотын олон хэрэглэгчдийн маань ирүүлсэн хүсэлт, саналын дагуу “Увс Хүнс” ХК нь өөрийн нэрийн бүх бүтээгдэхүүнээ АСА АРЕНА-д зохион байгуулагдаж буй “Жаргалтай золгоо” Цагаан сарын үзэсгэлэн худалдаа руу 2026 оны 01-02 саруудад илгээсэн. Манай итгэлт харилцагч **Амтлаг гэр/“Грийн Аая” био дэлгүүрийн Хүргэлт** хамт олны байрлаж буй лангуунаас манай бүтээгдэхүүнүүдийг хүргэлтээр түгээсэн.




“Увс Хүнс” ХК-ийн ээлжит орон нутгийн итгэлт түнш “Чанар” бөөний төв Эрдэнэт хотод албан ёсоор хамтын ажиллагаагаа эхлүүлсэн.





“Увс Хүнс” ХК Ус ундааны Foodex 2026 үзэсгэлэнд Увсын Чацарганатай бүтээгдэхүүнээ танилцуулж байна. Японы Токио дахь “Tokyo Big Sight” үзэсгэлэнгийн E7-A01 тоот павилонд бүтээгдэхүүнээ сурталчлан танилцуулж ажилласан.





Сар шинийн баярт зориулсан үзэсгэлэн худалдаанд үйлдвэрийн бүтээгдэхүүнээрээ оролцож, бүтээгдэхүүний сурталчилгаа, борлуулалтыг идэвхжүүлэн, хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ шууд танилцуулж ажилласан.

Уламжлалт амтыг үйлдвэрийн стандарттай хослуулсан “Увс Хүнс” ХК-ийн Цагаан сарын бүх бүтээгдэхүүнүүд хэрэглэгчдийн гарт хүргэсэн





Чацарганы тос олон улсын стандарттай болох шинэ шатанд шилжлээ. 2026 оны 2-р сарын 9-13-ны өдрүүдэд Малайз Улс, Куала Лумпур хотноо зохион байгуулагдсан.

Codex Alimentarius Commission-ийн дэргэдэх Өөх тосны асуудлаарх техникийн хорооны 29 дүгээр хуралдаанд (CCFO29) Монгол Улсын санаачилсан чацарганы тосны олон улсын стандарт боловсруулах санал албан ёсоор ажил хэрэг болохоор дэмжигдсэн.

Энэхүү шийдвэр нь чацарганы үрийн болон зөөлөн эдийн тосыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай болгох чухал алхам болсон. Монгол Улс тус стандартыг боловсруулах Цахим ажлын хэсгийг ахлан ажиллахаар болсноор дэлхийн зах зээлд чацарганы тосны үнэ цэнэ, чанар, аюулгүй байдлыг нэгдсэн шаардлагаар баталгаажуулах ажил эхэлсэн. “Увс Хүнс” ХК нь уг олон улсын хуралд чацарганы тосны бүтээгдэхүүний танилцуулга хийж, дээж бүтээгдэхүүнээ илгээж олон улсын төлөөлөгчдөд танилцуулсан.

Бид байгалийн цэвэр түүхий эд, жимсний тосоо агуулсан бүтээгдэхүүнээрээ Монгол Улсын чацарганы салбарын үнэ цэнийг олон улсын тавцанд таниулж байгаадаа бахархаж байна.

“Увс Хүнс”-Увсаас дэлхийд.





Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлэгчдийг урамшуулах журмын шинэчилсэн төслийн урьдчилсан хэлэлцүүлэг болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ын шинэчилсэн төслийн урьдчилсан хэлэлцүүлгийг 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.

Уг хэлэлцүүлэгт Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Үндэсний итгэмжлэлийн төв, Эс Эф Си Эс ХХК, Пийпл Ин Нийд, Тогтвортой санхүүжилтийн холбоо, Kingspan Mongolia ХХК, “Увс Хүнс” ХК, Иромик ХХК, Юрика ХХК болон бусад оролцогч талуудын төлөөлөл оролцож, журмын хэрэгжилтийн нөхцөл, шалгуур үзүүлэлт, урамшууллын механизм, институцийн уялдааг тодорхой болгох чиглэлээр санал солилцсон.

Хэлэлцүүлгийн үеэр өмнөх журмын хэрэгжилтэд баталгаажуулалтын тогтолцоо тодорхойгүй, шалгуур үзүүлэлт ойлгомжгүй байсан нь хүндрэл үүсгэж байсныг онцлон, шинэчилсэн төсөл нь бүртгэл болон урамшууллын үйл явцыг илүү тодорхой, ил тод болгоход чиглэж байгааг танилцуулсан. Оролцогчдын зүгээс гарсан саналыг нэгтгэж, журмыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах болсон.

ToC Холбоо / MSFA

People in Need - PIN Mongolia

Development Solutions NGO - Хөгжлийн Шийдэл ТББ

Caritas Czech Republic in Mongolia





2026 оны 03 сарын 20-д ЖДҮ-ийг дэмжих зээлийн төслийн судалгаанд оролцсон. Япон улсын Засгийн газрын ЖАЙКА (JICA)-аас хэрэгжүүлж буй Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын ЖДҮ-ийг дэмжих хоёр шатлалт зээлийн төслийн судалгаанд “Увс Хүнс ХК” салбараа төлөөлөн оролцсон. Уг уулзалтаар зээлийн хүү, хугацаа, хүртээмжийн нөхцөл, мөн аж ахуйн нэгжүүдэд тавигдах шаардлагуудын талаар санал солилцож ЖДҮ, бичил бизнес тэр дундаа экспортод гарахаар төлөвлөж буй ААН-үүдийг түлхүү дэмжих шаардлагатайг онцолсон. Түүнчлэн экспортод гарахад тулгарч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд илүү бодит дэмжлэг үзүүлэх санал, хүсэлтийг илэрхийлсэн. Ийнхүү ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллахад өөрсдийн хувь нэмрээ оруулахыг зорьсоор байна.



МУ-н Ерөнхийлөгч У.Хүрэлсүх "Увс Хүнс" ХК-д зочилсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2026.03.23нд "Увс Хүнс" ХК-ийн үйлдвэрт зочилж, үйл ажиллагаатай танилцсан. Энэ нь төрийн тэргүүний очиж ажилласан 122 дахь үндэсний үйлдвэр боллоо. Ерөнхийлөгчид үйлдвэрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бүтээгдэхүүн, Увсын чацарганыг газарзүйн заалттай бүтээгдэхүүн болгон Европын Холбоонд бүртгүүлсэн амжилт, мөн орон нутагтаа ажлын байр бий болгож, эрүүл чанартай хүнсний бүтээгдэхүүнээр бүс нутгийн хэрэглэгчдийг ханган ажиллаж буйгаа танилцуулсан. Тэрээр орон нутагт ажлын байр бий болгож, ард иргэдийг эрүүл хүнсээр тогтвортой ханган ажиллаж буйг өндөрөөр үнэлж, манай хамт олны хөдөлмөр, хичээл зүтгэл, ололт амжилтыг сайшаан тэмдэглэсэн.








Монгол, Японы судалгаа хөгжүүлэлт болон эрдэмтдийн баг Монгол чацарганы орц найрлага дахь үнэ цэнийг алдагдуулахгүйгээр инноваци шингэсэн ОНЦЛОГ бүтээгдэхүүн хийх талаарх 2 дахь удаагийн уулзалтаа Улаанбаатар хотод зохион байгуулсан.

Уулзалтаар цаашдын хамтын ажиллагааны чиг хандлага, боломжит санаа, инновац шингэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн гарцуудыг дэлгэрэнгүй хэлэлцсэн.

Ингэснээр Монгол чацарганы үнэ цэнийг олон улсын зах зээлд таниулж, дэлхийн хэрэглэгчдийн гар дээр хүргэх зорилт үе шаттайгаар бодит ажил хэрэг болон хэрэгжиж эхэлж байна.

Цаашид талууд туршилт судалгаа, хамтарсан бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлийн нэвтрэлтийн чиглэлээр нягт хамтран ажиллах бөгөөд Монгол чацарганын нэмүү өртгийг өсгөж, экспортын чадавхыг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.





Борлуулалтын сүлжээг өргөжүүлэх, хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээг илүү ойр хүргэх зорилтын хүрээнд Увс Хүнс ХК нь Улаангом хотод шинэ салбараа нээн үйл ажиллагааг эхлүүлсэн.

Шинэ салбар ашиглалтад орсноор бүтээгдэхүүний хүртээмж нэмэгдэж, хэрэглэгчдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, борлуулалтыг өсгөх, брэндийн танигдах байдлыг бэхжүүлэх нөхцөл бүрдсэн.

“Увс Хүнс” ХК УЛААНГОМ ХОТОД ШИНЭ САЛБАРАА НЭЭЛЭЭ

"Увс Хүнс" ХК нь 2026 оны 04 сараас Улаангом сумын 3-р багийн хэрэглэгч та бүхэндээ илүү ойртож Дун цагаан өрхийн эмнэлгийн дэргэд шинэ салбар дэлгүүрээ нээлээ.

Та бүхэн манай шинэ салбар дэлгүүрээс:

🍌 Шинэхэн гурилан бүтээгдэхүүн

🍊 Чацарганын олон төрлийн бүтээгдэхүүн

💧 Цэвэр ус, бэлгийн багцнууд

🚗 Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн зэрэг хэрэгцээт бараагаа нэг дороос авах боломжтой.





Тогтвортой ирээдүйн төлөөх хамтын ажиллагаанд “Увс Хүнс” ХК нэгдсэн.

“Mongolia Sustainable Beverage Packaging Forum 2026” арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан Тогтвортой сав баглаа боодлын зөвлөлийг байгуулах санамж бичигт гарын үсэг зурах ёслолд “Увс Хүнс” ХК оролцож, салбарын бусад төлөөллүүдтэй хамтран тогтвортой хөгжлийн зорилгын төлөө нэгдсэн.


Энэхүү зөвлөл нь үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага (EPR)-ыг хэрэгжүүлэх, дахин боловсруулалтын тогтолцоог дэмжих, тогтвортой сав баглаа боодлын шийдлүүдийг хөгжүүлэх, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой юм.

“Увс Хүнс” ХК нь байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, хариуцлагатай хэрэглээ, нөөцийн үр ашигтай ашиглалтыг дэмжих чиглэлээр тогтвортой хөгжлийн бодлогоо хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэхүү зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон салбарын хамтын хөгжилд хувь нэмрээ оруулах болно.

Бид тойрог эдийн засгийг дэмжих, сав баглаа боодлын хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулалтын үнэ цэнийн сүлжээг бэхжүүлэх бодит алхмуудад хамтран ажиллах болно.

[#УвсХүнсХК](#) [#SustainablePackaging](#) [#CircularEconomy](#) [#ESG](#) [#EPR](#) [#ТогтвортойХөгжил](#)





"Увс Хүнс" ХК нь 2026 онд Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) менежментийн тогтолцооны TQCSI ESG Code:2024 стандартын дагуу баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдаж, гэрчилгээний болзол хангасан.





Эрсдэл, дотоод аудит


Эрсдлийн төлөвлөгөө гарган бүртгэл хийж, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн арга хэмжээний хэмжилтийг ханган, удирдлагын дүн шинжилгээний хурлаар чанарын багт хэлэлцүүлэн шийдвэрээ гаргадаг.

Дотоод аудитын хөтөлбөрийн дагуу 2026.06.22-06.29-ний өдрүүдэд аудит хийн засан сайжруулах хугацаа өгөн тайлангаа гарган дүгнэсэн.

TQSCI компанийн Б.Оюунтөгс, Г.Цогтбаатар мэргэшсэн аудиторуудаас дараах агуулгаар дотоод аудиторын цахим сургалтыг 2026.04.09-04.10-ны өдрүүдэд авч 14 ажилтан бэлтгэн чадавхжуулж, шалгалт өгөн сертификатаа гардан авсан.

Сургалтын агуулга:

1. ISO22000:2018, ISO9001:2015 стандартын ойлголт
2. ISO22000:2018, ISO9001:2015 стандартын шаардлага
3. ISO19011:2018 стандартын шаардлага хангасан аудит зохион байгуулах нь



Нийгмийн хариуцлагын хүрээнд

Дээрлэхэлтийн эсрэг зохион байгуулсан “Дээрлэхэгч биш дэмжигч байя” мэтгэлцээний тэмцээнийг Увс аймгийн Ерөнхий Боловсролын 3-р сургууль, “Увс хүнс” ХК, Увс аймгийн хүүхдийн зөвлөл болон Увс аймаг дахь шүүхийн тамгын газартай хамтран Увс аймгийн Улаангом сумын нийт сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын хүрээнд 18 хүүхдийг оролцуулан нийт 6 баг бүрэлдэн “Үе тэнгийн дээрлэхэлтийн эсрэг” мэтгэлцээний тэмцээнийг ЕБ-ын 3-р сургууль болон Увс аймаг дахь Шүүхийн тамгын газарт тус тус зохион байгуулсан.

Увс аймгийн Хүүхдийн зөвлөл





Нийгмийн хариуцлагын хүрээнд

Компанийн зүгээс Увс аймгийн хүүхдийн зөвлөлийг дэмжин ажилласан бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн мэдээллээ ирүүлсэн. Үүнд: Увс аймгийн хүүхдийн зөвлөлөөс зохион байгуулсан “Өв тээгч” өдөрлөгийг Увс аймгийн хүүхэд гэр бүлийн Хөгжил хамгааллын газар, “Увс Хүнс” ХК-тай хамтран 2026 оны 05-р сарын 16-нд БНМАУ-ын баатар Б.Гивааны талбай дээр зохион байгуулж танхимаар 150, цахимаар 6200 хүнд хүрч ажилласан. Тус өдөрлөгийн зорилго нь монголчуудын эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлс, өв соёл, уламжлалт ёс заншлыг хүүхэд, залуучууд болон иргэдэд таниулах, өвлүүлэн үлдээх, мөн бүтээлч сэтгэлгээ, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн юм.

“Өв тээгч” өдөрлөг нь 6 өртөөтэйгээр зохион байгуулагдсан. “Монгол үндэсний хувцас” өртөөнд оролцогчид үндэсний хувцасны онцлог, бэлгэдлийн талаар мэдлэгээ сорьсон “Цагаан идээ” өртөөг “Увс Хүнс” ХК-аас дэмжлэг авч чацарганы чанамал, чацарганы шүүс, бяслаг оролцогчдод амтлуулан хэрэглэж, үндэсний цагаан идээний хэрэглээ, ач холбогдлыг таниулах үйл ажиллагаанд ашигласан. Мөн “Нутгийн аялга” өртөөнд нутгийн онцлог үг хэллэг, аялгууг таах, “Шагай наадгай” өртөөнд уламжлалт тоглоом наадгайгаар өрсөлдөх, “Ёс заншил” өртөөнд монгол ёс заншилтай холбоотой мэдлэгээ сорих, “Язгуур урлаг” өртөөнд үндэсний урлаг, өв соёлын талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулсан.





**Нийгмийн
хариуцлагын хүрээнд**

“Увс Хүнс ХК нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Увс аймаг дахь салбартаа хамтран Хүүхдийн марафоныг дэмжин ажилласан.

Увс аймгийн Хүний эрхийн салбар комисс үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох, түүний хор уршиг, сөрөг үр дагаврыг таниулах, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөв хандлага, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Увс аймагт хоёр дахь удаагаа Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хүүхэд бүр ялагч-Хүүхэд бүр хамгаалагч” хүүхдийн марафоныг хүүхдийн баярын арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулан 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 10:30-14:30 цагийн хооронд Биеийн тамир, спортын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Цагдаагийн газар, Увс Хүнс ХК, Эрүүл мэндийн газар, Улаангом сумын Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагуудтай хамтран “Хүүхдийн марафон-2026”-д нийт 1008 хүүхэд 6 насны ангилалаар амжилттай зохион байгуулсан.





Нийгмийн хариуцлагын хүрээнд

“Увс Хүнс ХК нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) чиглэлээр хэрэгжүүлж буй туршлагаа түгээсэн. Компани нь Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ) чиглэлээр урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа хэрэгжүүлж, байгууллагын дотоод соёл болон орон нутгийн иргэдэд чиглэсэн олон ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсээр байна. Энэ хүрээнд Увс аймгийн Номын сан, Музейн албан хаагчдад зориулан байгаль орчин, нийгмийн хариуцлага болон өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийн талаар сургалт амжилттай зохион байгуулсан.

Сургалтад хамрагдсан оролцогчид:

-  Байгаль орчноо хамгаалах зөв дадал
-  Ус, эрчим хүчээ хэмнэх арга
-  Хог хаягдлыг зөв ангиалан ялгах мэдлэг
-  Хашаандаа өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжуудын талаар мэдээлэл, туршлагаас хуваалцсан.



Нийгмийн хариуцлагын хүрээнд

“Увс Хүнс” ХК байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) чиглэлээр хэрэгжүүлж буй туршлагаа түгээсэн. Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ) чиглэлээр урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа хэрэгжүүлж, байгууллагын дотоод соёл болон орон нутгийн иргэдэд чиглэсэн олон ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсээр байна. Энэ хүрээнд "Youth Power" чуулганы монголын ирээдүй болсон оюунлаг, байгальд ээлтэй 9-12 ангийн сурагчиддаа байгаль орчин, нийгэм засаглал, нийгмийн хариуцлагын талаар сургалт амжилттай зохион байгуулсан.

Сургалтад хамрагдсан сурагчид:

-  Байгаль орчноо хамгаалах зөв дадал
 -  Ус, эрчим хүчээ хэмнэх арга
 -  Хог хаягдлыг зөв ангиалан ялгах мэдлэг мэдээлэл, туршлагаас суралцсан.
- "Youth Power in Uvs" сурагчдын бүлгэм





Бүтээгдэхүүн

“Увс Хүнс” ХК 2026 онд дараах шинэ бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ хүргэж байна.

2026 оны шинэ бүтээгдэхүүний судалгаа туршилт амжилттай болж чацарганатай амттан буюу жэли худалдаанд гаргахад бэлэн болоод байна.



Шар сүүний иштэй чихэр





Хандтай хундагатай Хан Хөхий архи гаргасан

330 мл савлагаатай цэвэр ус гаргасан.



Увс аймгийн 100 жилийн ойн хүрээнд зочдын бэлгийн сонголтод Монконди компанитай хамтран шинэ бүтээгдэхүүн болох чацарганатай хатуу чихрийг худалдаанд гаргасан.




“Саян” шоколадны үйлдвэртэй хамтран чацаргана, арвайн гурил, нэрс агуулсан “Улаангом” шоколад үйлдвэрлэсэн. Цайны хужир мөн бэлгийн сонголтод савлан гаргасан.





Байгаль дэлхийн гайхамшиг, чацарганы өлгий нутаг Увсаас танд зориулав. Увс нутгийн нэрийн хуудас болсон, газарзүйн заалттай, 100% Чацарганы тостой саванг бүх насныханд зориулан гаргасан. Олон удаагийн туршилтын үр дүнд “Арьсны эмч” Чацарганатай саванг Монгол хонины сүүлэн тостой зохист харьцаатайгаар хольсон нэн тааламжит орцтой тул нуур болон биенд хэрэглэхэд тохиромжтойгоор худалдаанд гаргасан.



Герман технологиор үйлдвэрлэсэн, шим тэжээлээр баялаг Чацаргана, Үхрийн нүд, Нэрс 3 төрлийн жимсний чанамлыг багц болгон гаргасан.





Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Л.Нямгэрэл

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: О.Оюунхүү

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: